

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2024 оны 07 дугаар сарын мэдээ

2024.07.23

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр:

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 15 албан бичиг ирсний 5 нь хариутай, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно. Сумын засаг даргын 06 дугаар сарын 24 өдрийн А/87 тоот захирамжаар сумын баяр наадмыг зохион байгуулах комисс томилогдон баяр наадмын үйл ажиллагааг 07 дугаар сарын 05,06 өдрүүдэд зохион байгууллаа.

Сумын баяр наадмаар Азрага-106, Их нас-60, Соёолон-47, Хязаалан-47, Шүдлэн-50, Даага-36 уралдсан байна. Хамгаалалтын хувцас хэрэглэлтэй, даатгалд хамрагдсан хүүхдүүд уралдааны замд гарсан бөгөөд уралдааны үеэр бэртэж гэмтсэн хүүхэд байхгүй болно. Хурдан морины уралдаанд хөрш зэргэлдээ Дорноговь аймгийн Өргөн, Дэлгэрэх зэрэг сумдаас морьд уралдсан.

Мөн сумын заан, сумын начин цолны болзол хангасан 2 иргэнд цолны үнэмлэх мөнгөн шагналыг сумын засаг даргын 2024 оны 07 дугаар 06-ний өдрийн А/90 дугаар захирамжаар олгосон.

Баяр наадмын талбайн зураг төсвийн ажлыг “Хот төлөвлөлт хүрээлэн” ХХК-р гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулаад байна.

Эрүүл мэндийн төвд шаардлагатай Шүдний эмчилгээний ор худалдан авах ажлыг Белладона ХХК -тай гэрээ байгуулсан.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: 2024 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ. Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг бүрэн орж хуваарилсан. Байгууллагуудын тогтмол зардлыг хуваарийн дагуу олгосон. Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Статистикийн мал эмнэлгийн мэдээ, зоогийн газрын мэдээ, үнийн мэдээ, аж үйлдвэрийн мэдээ,хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа, амьдрах орчин аюулгүй байдлын судалгааг хийсэн. Сар бүр орон нутгийн ерөнхий орлогыг тухай бүрд холбогдох дан руу хааж бичилтийг хийж гүйцэтгэж байна.

Төрийн албаны цалингийн нэгдсэн системд байгууллагууд цалинг урьдчилгаа болон сүүлийн хагасын цалин гэж 2 удаа бодон олгож байна. Төрийн сангийн цахим гүйлгээний систем санхүүгийн гүйлгээг тухай бүрд шивж цахимаар илгээж байна Хяналт шинжилгээ үнэлгээний санхүүтэй холбоотой тайлан мэдээ үзүүлэлтүүдийг цахим системд шивж оруулсан.

Санхүү аудитын газрын шалгалт ЗДТГ, ОНХС ХХС ийн 2024, 2023 оны баримт бичгийн шалгуулж заавар зөвлөгөө авсан. Хагас жилийн мал тооллого, хаягийн тодруулаг зэрэг мэдээ тайланг цаг хугацаанд статистик хэлтэст хүргүүлсэн

байна. Төрийн аудит газарт санхүүгийн тайлан гаргалтын судалгаа, статистикийн хэлтэс малын хорогдлын судалгаа зэргийг гаргаж хүргүүлсэн .

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Сумын баяр наадам болохтой холбогдуулан хурдан морь унаач хүүхэд, уяачдад зөвлөмж чиглэл өгч ажилласан. Мөн Эрүүл мэндийн төвтэй хамтарч хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах, хоол хүнсээр дамжих хордлого халдвар, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэг-634, Урьдчилан сэргийлэх үзлэг-274, Алсын дуудлага-23, Гэрийн дуудлага-62, Идэвхитэй хяналт-84, Рентген зураг авалт-30, Өдрийн эмчилгээнд-20, Сэргээн засах эмчилгээ-58 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

7 хоног бүрийн 4 дахь өдрийн 14:30 минутаас дотоодын сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Үүнд: Харшлын өвчний цогц менежмент, Зоонозын өвчний хариу арга хэмжээний талаар болон Артерийн даралт ихсэлтийн аян-2024 сургалт

Олон найрлагат бичил тэжээл 400 ширхэг ирснээс 100 хүүхдийг хамруулсан байна. Үүнийг ЭМГ болон НҮБ-ээс шалгалт хийж хамрагдалтыг тулгаж ажилласан.

Соёл: АХ-ын 103, Баяндэлгэр сум үүсэн байгуулагдсаны 99 жилийн ойн баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа, Баярын хурал зэргийг зохион байгуулах ажилд оролцов. Баяр наадмын үеэр “Морьтон Монгол”, Морин буухиа” тэмцээн “Дээлтэй Монгол наадам “ жагсаал зэргийг зохион байгууллаа.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Сумын хэмжээнд 8 ногоон байгууламжийн 19750 модны усалгаа арчилгааг 2 усны машин, 6 иргэний бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн